

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ, СУНГАХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ, БИЕЛЭЛТЭНД НЬ ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Харилцаа холбооны тухай Монгол Улсын хуулийн 4-р бүлэг болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийг үндэслэн иргэн, хуулийн этгээдэд харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл, бүртгэлийн гэрчилгээ олгохтой холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2 Тусгай зөвшөөрлийг олгохдоо харилцаа холбоог хөгжүүлэхэд төрөөс баримтлах бодлого, хэрэглэгчдийн эрх ашигт нийцүүлэн ил тод, үр ашигтай, шударга өрсөлдөх нөхцлийг бүрдүүлэх зарчмыг баримтална.

Хоёр. Тусгай зөвшөөрөл, бүртгэлийн гэрчилгээ олгох

2.1 Тусгай зөвшөөрөл авах, эсвэл бүртгүүлэхээр хүсэлт гаргагч нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11-р зүйл, Харилцаа холбооны тухай хуулийн 13-р зүйлд зааснаар доорхи бичиг, баримтыг бүрдүүлж, Харилцаа холбооны зохицуулах хороонд /цаашид “Зохицуулах хороо” гэх/ ирүүлнэ. Үүнд:

- 2.1.1 Хавсралт 1-д заасан маягтын дагуу бөглөсөн тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл
- 2.1.2 Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг дагалдах дараахь бичиг, баримтууд
Үүнд:
 - 2.1.2.1. Тусгай зөвшөөрөл хүссэн албан бичиг
 - 2.1.2.2. Улсын бүртгэлийн гэрчилгээ, компаний дүрэм болон иргэний үнэмлэхний баталгаажсан хуулбар
 - 2.1.2.3. Ашиглах стандарт, технологи, техникийн үзүүлэлтүүд, ажиллагааны зарчимын тухай дэлгэрэнгүй танилцуулга
 - 2.1.2.4. Сүлжээ байгуулах, ашиглах бол бусад сүлжээнд холбогдох техникийн нөхцөл, боломжтойг тодорхойлсон бусад сүлжээ эзэмшигчдийн тодорхойлолт
 - 2.1.2.5. Үйлчилгээний үнийн санал
 - 2.1.2.6. Санхүү, эдийн засгийн чадавхийг нотолсон баримт бичиг:
 - сүүлийн жилийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан тэнцэл
 - үйл ажиллагаагаа эхэлж байгаа бол эхлэлийн баланс
 - тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулахад шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийн тооцоо
 - 2.1.2.7. Ажилтнуудын диплом, мэргэжлийн үнэмлэхний хуулбар

2.1.2.8. Радио давтамж ашиглах тохиолдолд Радио долгионы хуулинд заасан баримт бичиг

2.1.2.9. *Интернэт дэх эзэмшил нэр (domain name), цахим шуудангийн хаяг, эрх бүхий байгууллагаас интернэтэд эзэмшил нэртэй болохыг тодорхойлсон албан бичиг.*

2.2 Зохицуулах хорооны холбогдох алба нь бичиг баримтын иж бүрдлийг шалган хуудас бүрийг дугаарлаж, бүртгэлд дугаар, огноог тэмдэглэж, хүсэлтийг хүлээн авсанд тооцно. Ямар нэгэн бичиг, баримт дутуу бүрдүүлсэн тохиолдолд материалыг буцаана.

2.3 Харилцаа холбооны үйлчилгээг радио давтамж ашиглан эрхлэх бол уг радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл, тухайн радио давтамж ашиглан үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг хамтад нь нэг шийдвэрээр нэг этгээдийн нэр дээр олгоно.

2.4 Зохицуулах хороо нь материалыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 21 хоногийн дотор хүсэлтийг шийдвэрлэх бөгөөд магадлан шинжилгээ хийлгэх тохиолдолд энэ хугацааг 14 хоногоор сунгана.

2.5 Зохицуулах хорооны холбогдох алба нь тухайн тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хангаж байгаа эсэх талаар судлан, дүгнэлт гарган шаардлагатай бол өргөдөл гаргагчийн баримт бичгийг холбогдох байгууллагаар тусгай зөвшөөрлийг олгох эсэх асуудлыг Зохицуулах хорооны хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ.

2.6 Бүртгэлийн гэрчилгээ олгох асуудлыг холбогдох албаны дүгнэлтийг үндэслэн Зохицуулах хорооны дарга шийдвэрлэнэ.

2.7 Зохицуулах хороо нь Харилцаа холбооны тухай хуулийн 14.2-д заасныг үндэслэн тусгай зөвшөөрөл олгохоос татгалзаж, хариу тайлбарыг бичгээр өгнө.

2.8 Тусгай зөвшөөрөл авахын өмнө хүсэлт гаргагч нь тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлсэн зохицуулалтын үйлчилгээний эхний жилийн хөлсийг нэхэмжлэл хүлээн авснаас хойш нэг сарын дотор Зохицуулах хороонд төлнө. Хугацаанд нь төлөөгүй тохиолдолд тусгай зөвшөөрөл олгох шийдвэрийг хүчингүй болгоно.

2.9 Тусгай зөвшөөрлийг авахдаа улсын тэмдэгтийн хураамжийг төлсөн байна.

2.10 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлсэн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг дараа жилээс нь гэрээнд заасан хугацаанд төлнө.

2.11 Тусгай зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийн гэрээ, бүртгэлийн гэрчилгээг Зохицуулах хорооны дарга гарын үсэг зурж, баталгаажуулна.

2.12 Тусгай зөвшөөрөл нь гэрээний хамт хүчинтэй байна.

2.13 Гэрээнд тухайн тусгай зөвшөөрөлд хамааралтай нөхцлүүдийг тусгах бөгөөд тухайн байдлаас шалтгаалан харилцаа холбоог хөгжүүлэх төрийн бодлоготой уялдуулан тавигдах нэмэлт нөхцлүүдийг оруулж болно.

2.14 Тусгай зөвшөөрөл нь хавсралт 2, ба 3-д, бүртгэлийн гэрчилгээ нь хавсралт 4-д заасан загвартай байна.

Гурав. Тусгай зөвшөөрөл, бүртгэлийн гэрчилгээний хугацааг сунгах

3.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах тухай хүсэлтийг хугацаа дуусахаас 21-ээс доошгүй хоногийн өмнө гаргана. Хэрэв хүсэлт гаргаагүй бол тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан гэж үзэж, энэ талаар нийтэд зарлана.

Тусгай зөвшөөрлийг сунгуулахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:

3.2.1 Тусгай зөвшөөрлийг сунгуулах тухай хүсэлт, албан бичиг

3.2.2 Холбогдох төлбөр, хураамжийг төлсөн баримт

3.2.3 Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байсан талаар тайлан, мэдээлэл

3.2.4 Тухайн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл /хугацаа нь дуусч байгаа/

3.3 Зохицуулах хорооны холбогдох алба энэ журмын 3.2 дахь заалтад заасан бичиг баримтыг бүрэн бүрдүүлэн өгсөн тохиолдолд сунгуулах тухай хүсэлтийг хүлээн авсанд тооцно. Хүсэлтийг хүлээн авснаас хойш тусгай зөвшөөрөл эзэмшигч нь авсан тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хангаж ажилласан эсэхийг ажлын 5 өдрийн дотор хянан тогтоож, хугацааг сунгах асуудлыг Зохицуулах хорооны дарга шийдвэрлэнэ.

3.4 Хэрэв тусгай зөвшөөрөл эзэмшигч нь авсан тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хангаж ажиллаагүй тохиолдолд Зохицуулах хороо тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах боломжгүй шалтгааныг болон түдгэлзүүлэх эсвэл хүчингүй болгох талаар Зохицуулах хорооны хуралдаанаар хэлэлцүүлж, хуралдааны шийдвэр болон тайлбар хариуг бичгээр өгнө.

3.5 Бүртгэлийн гэрчилгээний хугацааг сунгуулах тухай хүсэлтийг хугацаа дуусахаас 14-өөс доошгүй хоногийн өмнө явуулсан үйл ажиллагааны талаархи танилцуулга, шаардлагатай статистик мэдээллийн хамт гаргаж өгөх ба Зохицуулах хорооны даргын шийдвэрээр бүртгэлийн гэрчилгээг ажлын 3 өдрийн дотор сунгана.

3.6 Бүртгэлийн гэрчилгээг сунгуулах тухай хүсэлт тавиагүй бол олгосон огнооны дараагийн өдрөөр гэрчилгээг дуусгавар болгож бүртгэлээс хассан тухай нийтэд мэдээлнэ.

Дөрөв. Тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулах

4.1 Тусгай зөвшөөрлийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлэхийг хориглоно. Харин тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрчлөгдөн зохион байгуулагдсан, хамтарсан хуулийн этгээд байгуулсан буюу компанийн хуулийн дагуу нэгдсэн бол удирдах дээд шатны байгууллагын шийдвэр, шинэчилсэн аж ахуйн нэгжийн бүртгэлийн гэрчилгээ, бусад нотлох баримт бичгийг үндэслэн тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулна.

4.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулах хүсэлтээ шалтгаан тайлбар, удирдах дээд шатны байгууллагын шийдвэр, үндэслэл, нотлох баримт бичиг зэргийн хамтаар Хороонд бүрдүүлж өгнө.

4.3 Зохицуулах хорооны холбогдох алба нь хүсэлтийг хянан үзэж, санал дүгнэлт гарган Зохицуулах хорооны хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ. Шаардлагатай гэж үзвэл шалгана.

4.4 Зохицуулах хороо нь хууль тогтоомжийн дагуу тусгай зөвшөөрөлд өөрчлөлт хийхээр бол тусгай зөвшөөрөл эзэмшигчид урьдчилан бичгээр мэдэгдэнэ.

Тав. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох

5.1 Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13-р зүйлийг баримтлан тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлнэ.

5.2 Харилцаа холбооны тухай хуулийн 15-р зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14-р зүйлийг баримтлан тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

5.3 Түүнчлэн Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5.3 дахь заалтыг зөрчсөн тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

5.4 Харилцаа холбооны нийтийн үйлчилгээг радио давтамж ашиглан эрхлэж байсан бол уг радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон тохиолдолд, тухайн радио давтамж ашиглан үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл нь нэгэн адил хүчингүйд тооцогдоно.

5.4 Хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийг хураан авч, тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон харъяалах татварын албанд мэдэгдэж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлана.

Зургаа. Тусгай зөвшөөрөл, гэрээний биелэлтэнд хяналт тавих

6.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гэрээнд заасан үүргээ хэрхэн ханган ажиллаж байгаа талаар жил бүрийн 1-р сарын 25-ны дотор тайлан гаргаж өгөх ба Зохицуулах хороо үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгнө.

6.2 Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хэрхэн биелүүлж байгаад Зохицуулах хорооноос хяналт тавьж, зөрчсөн тохиолдолд захиргааны хариуцлага хүлээлгэх тухай санал гаргах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох зэргээр зөрчлийн нөхцөл, байдлаас нь хамааруулан холбогдох арга хэмжээг авна.

6.3 Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилт, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд өгсөн үнэлэлт, дүгнэлт, илэрсэн зөрчил, дутагдал, тэдгээрийг арилгах талаар авсан арга хэмжээ зэрэг мэдээллийг Зохицуулах хороо нь өөрийн вэб хуудас болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлж байна.

Долоо. Бусад

7.1 Зохицуулах хороо нь тусгай зөвшөөрлийн ангилал, төрөл бүрээр нь нэгдсэн бүртгэл гаргаж, тухайн тусгай зөвшөөрөл, түүнийг эзэмшигчийн талаархи техник, эдийн засгийн болон статистик мэдээллийг хадгалж, баяжуулж нэгтгэнэ.

7.2 Тусгай зөвшөөрөлтэй холбоотой материал, баримт бичиг нь зохицуулах хорооны нууцлалын журмын дагуу Зохицуулах хороонд хадгалагдана.

7.3 Зохицуулах хорооны шийдвэрээр олгогдсон, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлүүдийг өдөр тутмын олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

/Энэ журамд 2003 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 39, 2004 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 36, 2007 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 23, 2008 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 08 дугаар тогтоолоор орсон нэмэлт өөрчлөлтүүдийг тус тус тусгасан болно./

----- о О о -----

“А” АНГИЛАЛ

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ БАЙГУУЛАХ, ТҮҮНИЙГ АШИГЛАХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар

1. Гэрчилгээний дугаар
Регистрийн дугаар

/аж ахуйн нэгж, байгууллагын нэр, гэрчилгээний дугаар/

2.

/орших газрын хаяг, телефон утас, факсын дугаар/

3.

/сүлжээний төрөл, хамрах хүрээ /

4. Эхлэх Дуусах

/ тусгай зөвшөөрлийн хугацаа /

5. Тусгай зөвшөөрөл нь гэрээний хамт хүчинтэй.

Тамга
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА

... оны ... сарын ... –ны өдөр

“Б”АНГИЛАЛ

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар

1.

/аж ахуйн нэгж байгууллагын нэр, гэрчилгээний дугаар/

2.

/орших газрын хаяг, телефон утас, факсын дугаар/

3

/үйлчилгээний төрөл, харах хүрээ/

4.

Эхлэх

Дуусах

/тусгай зөвшөөрлийн хугацаа/

5. Тусгай зөвшөөрөл нь гэрээний хамт хүчинтэй.

Тамга

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА

.... оны сарын-ны өдөр

Хавсралт 4

БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар

1.

/аж ахуйн нэгж байгууллагын нэр /

2.

/орших газрын хаяг, телефон утас, факсын дугаар/

3.

/ашиглалт, үйлчилшгээний төрөл, хамрах хүрээ/

4. Эхлэх

Дуусах

/ бүртгэлийн гэрчилгээний хугацаа/

Тамга

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА

.... оны сарын-ны өдөр

Сунгалт:

Эхлэх

Дуусах

/ эрхийн хугацаа /

Тамга

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ

ХОРООНЫ ДАРГА

.... оны сарын –ны өдөр

Сунгалт:

Эхлэх

Дуусах

/ эрхийн хугацаа /

Тамга

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ

ХОРООНЫ ДАРГА

.... оны сарын –ны өдөр

Сунгалт: нэмэлт салбаруудын хувьд

Эхлэх

Дуусах

/ эрхийн хугацаа /

Тамга

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ

ХОРООНЫ ДАРГА

.... оны сарын –ны өдөр

Сунгалт:

Эхлэх

Дуусах

/ эрхийн хугацаа /

Тамга

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА

.... оны сарын –ны өдөр